



ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ  
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

# ЗӨВЛӨМЖ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ  
УЛС ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ ХАНГАХ

УЛААНБААТАР ХОТ  
2021 ОН

## Нэг. Хэрэгцээ, шаардлага

### Статистик баримт

Монгол улсад хөгжлийн бэрхшээлийг хараа, хэл яриа, сонсгол, хөдөлгөөн, сэтгэц, хавсарсан, бусад гэж 7 төрлөөр тодорхойлдог. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоос 50 болон түүнээс дээш хувиар хөдөлмөрийн чадвар алдсан гэж тогтоосон иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй гэж үздэг. Үндэсний статистикийн хорооны 2020 оны жилийн эцсийн мэдээгээр монгол улсад нийт **108399** (нийт хүн амын 33%) хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас **35556** иргэн нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна. Сонгуулийн насанд хүрсэн 18 түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэн **96904** байгаа нь нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 89,4 % эзэлж байна. Бэрхшээлийн төрлөөр нь харахад харааны бэрхшээлтэй **10747**(11.1%), ярианы бэрхшээлтэй **3241**(3.3%), сонсголын бэрхшээлтэй **8103** (8.3%), хөдөлгөөний бэрхшээлтэй 19387 (20%), сэтгэцийн бэрхшээлтэй 18539 (19.1%), хавсарсан бэрхшээлтэй 6567(6.7%), бусад 30320 (31.2%) иргэн байна. Бусад болон хавсарсан бэрхшээлтэй иргэд нийт ХБИ-ийн 37%-ийг эзэлж байгаа нь бэрхшээлийн төрлөөр ангилах боломжгүй, төрөл бүрийн хэрэгцээ шаардлагатай иргэд байна гэсэн үг юм.

### Хууль эрх зүй

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”-ын 29 дүгээр зүйлд “Улс төр, нийгмийн амьдралд оролцох”;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6.3.6-д “Төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзах, зайлсхийх, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байх” нь ялгаварлан гадуурхах нэг хэлбэр;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх”;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 30 дугаар зүйлд “Улс төрийн үйл ажиллагаанд оролцох”;

### Нөхцөл байдал

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлж чадахгүй байх тохиолдол цөөнгүй гарч байгаагийн шалтгаан нь нэг талаас хөгжлийн бэрхшээлийн улмаас улс төрийн оролцоо нь хязгаарлагдах, нөгөө талаас улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр, мэдээлэл, сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт тохируулсан хэлбэрээр явагддаггүйн улмаас мэдээллийг бүрэн хүлээж авч чадахгүйн улмаас сонгох эрхээ хэрэгжүүлж чадахгүй байна;
- Улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрийн хүртээмжийг сайжруулах талаар зөвлөгөө, зөвлөмжийг төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудаас удаа дараа хүргүүлдэг хэдий ч дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй;
- Мэдээллийн саад бэрхшээлийг багасгах “Саадгүй байдлыг бий болгох” арга хэмжээ авах нь зайлшгүй. Улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгогдох эрх, сонгох эрхийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах “Тэгш хамруулсан санал өгөх” боломж бүрдэнэ.

### Хоёр. Зөвлөмжийн зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний улс төрийн сонгуульд оролцох мэдээллээр хангах төдийгүй улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг саадгүй, хүртээмжтэйгээр авах боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

### Гурав. Арга хэмжээ ба жишээ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 онд Сүхбаатар дүүрэг болон Баянзүрх дүүргийн сонгуулийн санал авах байрны зам талбайн дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээний дүгнэлт, мөн Түгээмэл хөгжил ТББ-тай хамтран Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газруудын дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн үнэлгээ хийсэн ажлын тайлан, Азийн сангийн тэтгэлгээр Түгээмэл хөгжил ТББ-аас явуулсан 2020 оны УИХ-ын сонгуулийг угтаж сонгуулийн санал авах байрны хүртээмжийг нэмэгдүүлэх талаар хийгдсэн судалгааны тайлан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын ШҮХЭР нэгдсэн бодлогын ерөнхий зөвлөлийн 2020 оны УИХ-ын сонгуулийн үйл ажиллагаан хөндлөнгийн хянал хийсэн ажлын тайлан, “Сонсголын бэрхшээлтэй сонгогч иргэн”, “Хөгжлийн бэрхшээлтэй сонгогч иргэн” төслүүдийн тайлан, мэдээллүүдэд үндэслэн дараах зөвлөмжийг боловсруулав. Үүнд:

### Саадгүй орчинг бүрдүүлсэн мэдээлэл өгөх байр

- Улс төрийн намын ажилтан нарын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт явуулж хөгжлийн бэрхшээлтэй сонгогч ирэхэд харилцааны саад учруулахгүй байхаар бэлтгэгдсэн байдлыг хангах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг хийж мэдээллийг хүртээмжтэй хүргэхэд анхааран ажиллах
- Мэдээлэл авах гэж ирж буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх туслах ажилтан, чиглүүлж өгөх хөтөч, тайлбарлагч ажиллуулах, эсвэл улс төрийн намын ажилтанг туслах үйлчилгээний арга барилд сургах
- Гэнэтийн осол аваарын үед хэрэглэх гарц, дуут дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлогт тохируулан тусгайлан бэлдэх, тухайлбал, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулсан дуут аваарын дохио, хараад унших ойлгомжтой зурагт хэлбэрээр илэрхийлсэн мэдээллийн самбар, брайл үсгээр илэрхийлсэн тэмдэглэгээ тавих
- Байнгын асаргаанд гэртээ болон асрамжийн төвүүдэд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг биечлэн түгээх

### Сонсголын бэрхшээлтэй иргэнд дэмжлэг үзүүлэх

- Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр улс төрийн намын ажилтан албан хаагчид дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулах
- Харилцах боломжгүй иргэдтэй харилцах самбар, таблет ашиглан эсвэл цаасан дээр бичих байдлаар харилцах
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх сонгуультай холбоотой аливаа мэдээ, мэдээллийг дохионы хэлний хэлмэрчтэй, эсвэл хадмал, урсдаг текстэн хэлбэрээр хүргэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах
- Сонсголын бэрхшээлтэй иргэнд биечлэн дохионы хэлмэрч орчуулагчаар туслалцаа үзүүлэх болон видеогоор дохионы хэлмэрчийн туслалцаа авах боломжийг бүрдүүлж өгөх
- Улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчийн талаарх танилцуулга, мэдээллийг видео хэлбэрт гаргахдаа дохионы хэл болон хадмал орчуулгатайгаар гаргах. Видеонд дохионы хэлний орчуулгыг дэлгэцийн гуравны нэгээс багагүй зайд тодорхой харагдахуйцаар байрлуулах


**Баримт 1.** 2020 оны УИХ хурлын сонгуулийн сурталчилгааны хугацаанд нам, эвсэл, бие даагч нарын 80 хувь нь сурталчилгааны видео, тараах материал зэрэгт дохионы хэлмэрч дохих, брайль хэл ашиглах, видеог аудио хэлбэрт шилжүүлэх зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл хүлээн авах боломжийг бүрдүүлээгүй. Тухайлбал, тус видео нь 1 минут 14 секунд үргэлжилдэг бөгөөд дохионы хэлмэрч дохих хэсэг дэлгэцэнд байхгүй, мэдээллийг урсдаг бичгэн хэлбэрээр оруулаагүй.

**Харааны бэрхшээлтэй иргэнд дэмжлэг үзүүлэх**

- Улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчийн тараах материалыг Монгол брайл үсгийн хөрвүүлэг /MNS 6800: 2019/ стандартын дагуу бэлтгэх
- Видео мэдээ, мэдээллийг харааны бэрхшээлтэй иргэнд зориулж дуу оруулж нэвтрүүлэх
- Гэрэлтүүлгийг саналын хуудас харагдахуйцаар бүрэн хэмжээнд тусгахад анхаарах
- Сул хараатай иргэдэд зориулсан мэдээллийн сонин, сэтгүүлийн үсгийн фондыг томоор хэвлэсэн байх
- Нэр дэвшигчийн зураг бүхий жагсаалтыг гаргах
- Шаардлагатай үед томруулагч шил өгөх
- Мэдээлэл өгөх байранд хөтөч замтай болгох- резинэн хөтөч зам хийх, чиглүүлэх бариул байршуулах
- Дотор шатыг хүртээмжтэй болгож, шатны гишгүүрийг резинэн товгор гадаргуутай болгох
- Шатны гишгүүрийн ирмэгийг тод өнгөөр ялгаж, бариул дээр нь давхрын дугаар заасан брайл тэмдэглэгээ хийх
- Хэрвээ Лифт ашиглахаар бол лифтний давхарын мэдээллийг монгол хэл дээр програмчлах
- Шаардлагатай үед хэрэглэх туслах тоног төхөөрөмжүүд болох тэргэнцэр, тулгуур алхуулагч, таяг бэлдэж байрлуулах



**Баримт 2.** “Монгол брайль бичгийн стандарт” батлагдаж монгол брайль үсгийн стандарттай болсон энэ хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэд нийгэмд тэгш оролцох эрхийг нь хамгаалахад чиглэсэн юм. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-д “Брайль бичиг нь хараагүй хүний хэрэглэдэг үндсэн бичиг бөгөөд брайль бичгийг ашиглан мэдээлэл авах, боловсрол эзэмшин нийгмийн харилцаанд оролцох нөхцөл боломжоор хангана” гэж заасан. Сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа, мөрийн хөтөлбөр нь “Брайль” цаасан дээр, товгор үсэгтэй (Брайль үсэг) тэмтрэн уншихаар хэвлэгдвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэн буюу хараагүй иргэдийн мэдээлэл авах байдал нь нэмэгдэнэ.



нийтэлнэ гэсэн заалтыг зөрчсөн ба уг сурталчилгаа нь нэр дэвшигчийн хувийн хуудаст нийтлэгдсэн бөгөөд 427 хүн сэтгэгдэл үлдээсэн байна.

**Хөдөлгөөний бэрхшээлтэй иргэнд дэмжлэг үзүүлэх**

- Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны үндсэн шаардлага /MNS 6055:2009/ стандартыг хангах
- Байгууламжийн гадна болон дотор жижиг шат довжоонд 1:12 м стандартыг баримтлан налуу зам хийх.
  - Налуу зам 0,2 м өндөрт гарах налуу <1:10 0,8 м үед түүнээс илүү өндөрт гарах үед <1:12, налуу замын өргөн 1200 мм
  - Налуу замын бариул, Том хүн 900 мм Хүүхэд 500-700 мм
- Хэрвээ намуудын үүрийн байр налуу замтай бол налуу замд бариул хийн, стандартын дагуу намсгаж, тэргэнцэртэй хүн ганцаараа чөлөөтэй зорчих боломжтой болгох



**Баримт 3.** Мэдээллийн сайтын мэдээ мэдээлэл, сурталчилгааны материалууд нь харааны бэрхшээлтэй иргэд, сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр хэвлэгдээгүй байна.

**Баримт 4.** Сонгуулийн тухай хуулийн 47.1.1, 47.1.3-т заасан цахим хуудас ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотойгоор



- Хэрвээ үүдний заланд шаттай догол хэсгүүд байгаа бол аль нэг буланд нь стандартын дагуу уналттай налуу бий болгох, эсвэл шатыг байхгүй болгож, үүдний хэсэгтэй жигд төвшинтэй болгох
- Байгууламжийн коридорын өргөн нь 1800 мм их байх. Учир нь хоёр тэргэнцэртэй хүн зөрөх тэргэнцэртэй хүн коридорт чөлөөтэй эргэх орон зайг тооцсон байх
- Коридорын өргөн нь хангалттай хүртээмжтэй хэдий ч дундаа хаалга, хаалт, мөн шаттай бол хаалга, хаалтыг авч, шатны хэсгийг налуулж тэргэнцэртэй хүн зорчих боломжтой болгох
- Цахилгаан шатгүй тохиолдолд тэргэнцэртэй хүнд зориулсан шатаар өгсөх өргүүр хийх
- Байгууламжийн гарц, орчны хаалганы өргөн 850мм< их байхаар тооцон шинэчлэх
  - Хаалганы өргөн >850 мм, босгоны өндөр<15 мм, давхар хаалга хоорондын зай 1200X1700 мм
- Мөн хаалгыг мэдрэгчтэй хаалгаар сольж болно
- Угтах үйлчилгээний /ресепшн/ /текийг хүртээмжтэй болгох, текний аль нэг хэсгийг намхан болгож доошлуулах зэрэг байдлаар өөрчилж, тавцангийн өргөн, тэргэнцэр орох зайг стандартын дагуу хийх
  - Текний өндөр- 70 см, тавцангийн өргөн- 100 см, тавцангийн тэргэнцэр орох зай- 50 см
- Өрөөний хаалганы үүдэнд тэмдэглэгээг хийх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний орон зайг тооцсон, туслах хэрэглэгдэхүүн бүхий ариун цэврийн өрөөг тохижуулах. Ариун цэврийн өрөө нь тэргэнцэртэй хүн бүтэн эргэх эргэлтийн орон зайг 1.5 м байхаар төлөвлөх
  - Ариун цэврийн өрөөний: Урт- 165 см, Өргөн- 180 см
- Угаагуурын өндөр нь 750мм-900мм байна.
  - Тэргэнцэртэй болон одон хүн гар нүүрээ угаахад тохирох өндөртэй байхаар тохижуулах
  - Усны цорго- крантыг мэдрэгчтэй болгох
  - Толийг нь бага зэрэг тонгойлгож тогтоох
- Хэрвээ Лифт ашиглахаар бол лифтний давхарын мэдээллийг монгол хэл дээр програмчлах
- Шаардлагатай үед хэрэглэх туслах тоног төхөөрөмжүүд болох тэргэнцэр, тулгуур алхуулагч, таяг бэлдэж байрлуулах
- Сонгогчдод мэдээлэл өгөх ширээг шалнаас 70-75 см өндөртэй ширээгээр солих
- Хурлын байр, хурлын индэрийг хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах

**Дараах зурагт үзүүлсэн шиг байж болохгүй !!!**



- Тухайн байгууламж руу чиглэх явган хүний замыг 100 м-ийн хүрээнд тэргэнцэртэй болон харааны бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлсэн саадгүй орчны төлөвлөлтийг хийх
- Замын гарц, орц дээрх явган замын хашлагыг налуулах
- Хэрвээ авто зогсоолтой бол хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан зогсоол төлөвлөх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний авто зогсоолыг бий болгож тэмдэг тэмдэглэгээг тавьж байршуулах
  - 100 машин 4% буюу 4-өөс багагүй байна.



## Дараах зурагт үзүүлсэн шиг байж болохгүй!!!



Улс төрийн нам, эсвэл, нэр дэвшигчигч, бие даагч нар мөрийн хөтөлбөр, танилцуулга, мэдээллээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт тохируулан бэлтгэж боловсруулахдаа ашиглахыг зөвлөж байна.